

ӨНГӨЦХӨН ИТГЭЛ

Charles Leiter

illbehonest.com/mongolian

Бүгдээрээ Иоханы 2:23-25 ыг уншицгаая “Есүсийг Дээгүүр Өнгөрөх баяраар Иерусалимд байхад нь олон хүн Түүний хийсэн тэмдэгүүдийг үзээд, Түүний нэрэнд итгэжээ. Харин Өөрийнхөө хувьд Есүс Өөрийгөө тэдэнд даатгасангүй. Учир нь Тэр бүх хүнийг мэдэж байв. Хүний дотор юу байдгийг мэдэж байсан тул хүний тухай хэн нэгний гэрчлэл Түүнд хэрэггүй байв.” Өнөөдөр би та нартай өнгөц, гүн биш итгэлийн талаар ярилцмаар байна. Өнгөц гэдэг бол гүн биш ердөө л гадаргуу дээр гэсэн үг Аварч чадахааргүй итгэл гэж байвал тэр нь өнгөцхөн итгэл л байна

Хамгийн түрүүнд бид эндээс Эзэн Есүс Христэд итгэсэн боловч гэм нүгэлдээ хутгалдсан хэвээр, аврагдаагүй байх боломжтойг харж байна. Эзэн Есүс Христэд итгэсэн ч тамд унах магадлал бий. Энэ бол үнэхээр цочирдом үг. Яагаад би ингэж хэлэв? Тэгэхээр бүгдээрээ Иоханы 2:23 ыг дахин харцгаая. “Есүсийг Дээгүүр Өнгөрөх баяраар Иерусалимд байхад нь олон хүн Түүний нэрэнд итгэжээ.” Тэд Түүний нэрэнд итгэсэн. “Харин Есүс Өөрийгөө тэдэнд даатгасангүй” Шинэ Америк стандартын орчуулгаар “найдах” гэдэг энэ үг нь “итгэх” гэсэн үгтэй ижил утгатай. Кинг Жэмис орчуулгатай библид “ даатгах” гэсэн үг хэрэглэсэн байдагийг би санаж байна. ИСВ дээр юу гэж байна вэ? Есүс яасангүй гэж байна вэ? Есүс тэдэнд даатгасангүй. Эдгээр үгс бүгд ижил утгатай Та нар “ олон хүн Түүний нэрэнд итгэсэн боловч Есүс тэдэнд итгэсэнгүй” гэж хэлж болно. Эсвэл олонх нь Түүний нэрэнд найдсан боловч харин Тэр тэдэнд найдсангүй гэж хэлж болно. бас Тэр Өөрийгөө тэдэнд даатгасангүй гэж ч болно. Тиймээс асуулт маань “ Эцсийн эцэст би Есүст итгэдэг үү?” гэдэгт бус харин “ Тэр надад найддаг уу? Тэр надад Өөрийгөө даатгасан уу?” гэдэгт байгаа юм.

Яагаад Есүс эдгээр хүмүүст Өөрийгөө даатгасангүй вэ? Би та нараас асууя, яагаад тэгээгүй юм бол? Сургаалын дундуур асуулт асууж болно гэж Сам хэлсэн болохоор би та нараас асууж байгаа юм. Иймэрхүү маягаар асуудаг уу? Яагаад Есүс Өөрийгөө тэдэнд даатгаагүй юм бол? (нэг эрэгтэй хүн хариулна.) “ Тэр бүх хүний зүрхийг мэдэж байсан” Яг зөв. Тэр хүмүүсийн зүрх сэтгэлийг мэдэж байсан. Өөрөөр хэлбэл, хэдийгээр тэд Түүнд найдаж, Түүний нэрэнд итгэсэн ч тэрхүү итгэл, найдвар нь ямар нэгэн юмаар дутмаг байсан байна Харин Тэр тэдний зүрх сэтгэлд юу байгааг мэдэж байсан. Тэдний итгэл гүн бус өнгөцхөн байгааг Тэр мэдэж байсан. нэг тийм өнгөцхөн, гадна талынх л байсан Тэд Түүний нэрэнд итгэсэн. харин Тэр тэдний зүрх сэтгэлийг мэдэж байсан болохоор Өөрийгөө тэдэнд даатгасангүй.

“ Английн хатан хааныг мэднэ” гэж миний хэлэх нэг хэрэг, харин хатан хаан юу гэж хэлэх нь өөр хэрэг гэдгийг та нар мэднэ. Юу гэсэн үг вэ гэхээр: Би ордны хаалган дээр очоод “ Би хатан хааныг танина” гэж хэллээ гээд би дотогш орж чадахгүй. Харин тэр намайг мэднэ гэвэл өөр хэрэг. Галат номын 4-р бүлэгт, Паул хэлэхдээ “одоо та нар Бурханыг таньж, тэр ч байтугай Бурхан та нарыг таньсан.” гэж гайхамшигтайгаар хэлсэн байдаг. Энд нэг юм хэлээд байгаа бус уу? Бурханаар мэдэгдэх, танигдах гэдэг үгс адилхан утгатай Тэгэхээр Эзэн тэдний зүрх сэтгэлийг мэдэж байсан тул тэдэнд Өөрийгөө даатгасангүй.

Тэд чин сэтгэлээсээ байгаагүй гэж хэлээгүйг анзаарч хараарай Хүн чин сэтгэлээсээ байж болно. Никодимийг авч үзье Түүний тухай дараагийг бүлэгт гардаг. Тэр үнэхээр чин сэтгэлээсээ байсан. Хүн ойлгож мэдэхийн тулд чин сэтгэлээсээ байж болох ч нөгөө талаар тал зассан, хайхрамжгүй байх гэхчилэн маш олон бодит бус байдлууд тэдний зүрхэнд байж байдаг. Тэд ихэнхдээ юу хийж байгаагаа ч мэддэггүй. Том том цугларалт, семенарын үеэр урагш гарч ирдэг хүмүүс үнэндээ хэнийг ч хуурч мэхлэхийг хүсдэггүй боловч ихэнхдээ тэд юу хийж байгаагаа ч мэддэггүй. Тэгэхээр бид иймэрхүү зүйлийг л энд ярьж байна. Бид чин сэтгэлээсээ байгаагүй талаар яриагүй. өнгөц байдлын талаар ярьж байна. Энэ бол” сэтгэлийг ялагчид” гэж хэлэгддэг нэртэй номлогчдын хамгийн том алдаа юм. Тэд бодохдоо тухайн хүн чин сэтгэлээсээ байвал өвдөг сөгдөөд залбирахад л Бурхан түүнийг сонсоно гэж боддог. тийм байж ч болно үгүй ч байж болно. Энд Иоханы 2-р бүлэгт хэлэхдээ, “Тэдгээр хүмүүс Түүний нэрэнд итгэсэн боловч харин Тэр Өөрийгөө тэдэнд даатгасангүй” гэж байна. Иймэрхүү том цугларалтуудад хүмүүс урагшаа гарч ирдэг, эсвэл хүмүүс олон удаа та нарын төлөө залбирцгаадаг. Тэд чин сэтгэлээсээ чадлынхаа хэрээр байдаг боловч тэр нь энд гарч байгаатай л адилхан зүйл болдог. Нэг талаар тэд итгэсэн ч тэр нь маш өнгөцхөн итгэл байдаг. Чин сэтгэлээсээ боловч маш өнгөц.

Гол асуудал нь: Хэрвээ чи хүний зүрх сэтгэлийг хөдөлгөж чадвал тэднээр ямар нэгэн шийдвэрийг гаргуулж болдог л байгаа юм. Олон удаа та нар ингэж чадна. Та нар ялангуяа хүүхдүүдтэй иймэрхүү байдлаар харьцдаг. “Чи там руу явмааргүй байгаа биз дээ? “чи аав ээжтэйгээ хамт баймааргүй байна уу?” гэхчилэн хэсэг зуур самгардуулсаны дараа тэднийг залбирахад бэлэн болгодог. Залбирлыг давтаж залбирах, эсвэл Есүст “ итгэх” нь юуг өөрчлөхгүй болохыг та нар харж байна уу? Ариун Сүнсний гэрчлэл зайлшгүй хэрэгтэй. Маш олон хүмүүс итгэлээ зөвхөн амаараа л хүлээн зөвшөөрч байгаа энэ үед чи чухам юугаараа өөр вэ? Би “Heart Cry” гэдэг байгууллагийн хүмүүстэй хамт Румын руу хэд хэдэн удаа явсан юм. Тэнд Америкийн олон олон сайн мэдээ тараагчид “бид 10,000 хүнийг Эзэн руу дагууллаа” гэцгээж байсан. Хэрвээ та нар энэ бүгдийг нэгтгээд үзвэл энэ үзүүлэлт нь Румыны нийт хүн амаас ч давсан тоо гарна. Зарим юм буруу байгаа биз!. Хүмүүсийн сэтгэлийг хөдөлгөж байгаад тэднийг залбируулаад л шийдвэр гаргуулдаг.

Түүхэнд Споржины тухай тэмдэглэхдээ: Түүний хүмүүст зөвлөгөө өгдөг цаг нь дахь өдрийн үдээс хойш байсан гэсэн байдаг. Түүнийг нас барсаны дараа нэг дагалдагч нь үүнийг бүтэн сайнд цуглааны дараа хийж эхэлжээ. Цуглааных нь нэг настай ахлагч түүнээс “ Яагаад ингэж байгаа юм бэ? “ гэхэд тэр хүн “ өө, би төмрийг халуун дээр нь цохих нь сайн гэдэгт итгэдэг” гэж хариулжээ. Өөрөөр хэлбэл, сэтгэл нь хөдөлсөн үед нь хүмүүсээр ямар нэгэн юм хийлгүүлэх гэсэн хэрэг. Настай ахлагч хариуд нь: “ Хэрвээ Бурхан тухайн төмрийг халаасан бол тэр төмөр дахь өдрийн үдээс хойш хүртэл халуун байна гэдэгт Споржин итгэдэг байсан” гэж хэлжээ. Та нар сэтгэл хөдлөлөөр удирдуулах хэрэггүй. Тэгэх албагүй. Хэрвээ бид үнэхээр итгэвэл бид хүмүүсийн амьдрал дахь Бурханы ажлыг хардаг. Мартин Лоёд- Жонсон нэг орой номлож байжээ. бүтэн сайны орой байсан шиг санаж байна. Тэр цугларалтанд нэлээд нэртэй архаг архичин ирсэн байв. Тэр хүн цуглааны турш уйлсаар байжээ. Цуглааны дараа Лоёд- Жонсон хүмүүсийг гаргаж өгч байхдаа “би энэ хүнд юм хэлэх үү болих уу?” гэж бодож байгаад хэлэхгүй байхаар шийджээ. Нөгөө хүн ч яваад өгсөн байна. Дараагийн өдөр нь, Лоёд- Жонсон гүүрэн дээр нөгөө хүнтэй таарчээ. Нөгөө хүн: “ Лоёд -Жонсон эмчээ, хэрвээ та өчигдөр орой надаас асуусан бол би Христчин болох байлаа” гэжээ.

Лоёд-Жонсон, “ Тэгвэл одоо цуглааны байранд очоод ярилцъя л даа” гэжээ. Харин нөгөө хүн, “ Үгүй ээ үгүй. Одоо би хүсэхгүй байна. Харин та өчигдөр орой л асуусан бол” гэжээ. Чухам юу болсоныг одоо та нар харж байна уу? Энэ нь жинхэнэ биш, зүгээр л сэтгэл хөдлөл байсан байна. Иймэрхүү юм дандаа болдог.

Эхнэр маань тиймэрхүү том цугларалтын үеэр урагш гарч Есүсийг хүлээж аваад New Guinea руу мишионерээр явах гэж байхдаа аврагдаагүй байгаага олж мэдсэн гэсэн. Тэгэхээр бид энэ тухай л ярилцаж байна. Жон Висли Америкт ирээд “ би Индиан хүмүүсийг өөрчлөх гэж ирээд харин өөрөө өөрчлөгдлөө” гэж хэлсэн байдаг.

Тэгэхээр ийм байна. Есүст итгэсэн ч гэм нүгэлтэй алдагдсан хэвээр байх боломжтой. Энэ бол өнгөц итгэл юм. Өнгөцхөн итгэл нь зөвхөн магадлалтай ч бус харин ч нийтлэг байдагийг анзаарч хараарай Энд хэлэхдээ Түүний нэрэнд олон хүмүүс итгэсэн гэж байна. -Олон Есүс Эзэн юу гэж хэлсэнийг санаж байна уу? Тэр хэлэхдээ,” Нарийн хаалгаар ор. Амь руу хөтөлдөг зам нь нарийн хаалга нь жижиг юм. Цөөхөн хүн түүнийг олдог. Сүйрэл рүү татан оруулдаг хаалга нь өргөн, зам нь уужим юм. Олон хүн түүгээр тийшээ ордог” гэсэн. Тэр энэ хэсгийг олонхи хүмүүсийн бодож байгаачлан хэлээгүй. Тэд хэлэхдээ ,” өргөн хаалга нь бусад шашинг төлөөлж байна эсвэл Гитлер шиг хүмүүсийнх юм” гэгцгээдэг. Үгүй дээ, энэ бүгд зөвхөн амаараа л хүлээн зөвшөөрдөг Христэд итгэгчдийг хэлж байгаа юм. яагаад гэвэл Тэр олонх цөөнхийн талаар хэлсэн байна. Олон хүмүүс Надад ,” Эзэн минь, Эзэн минь бид Таны нэрээр эш үзүүлж, Таны нэрээр чөтгөрүүдийг хөөж, Таны нэрээр гайхамшигуудыг үйлдэж байсан бус уу? гэж хэлэх болно”. гэсэн. Тэд бол Христэд итгэдэг гэж хэлдэг хүмүүс юм. Тиймээс өргөн хаалга, жижиг хаалга буюу нарийн зам нь Христэд итгэдэг гэж хэлэгчдийнх юм Хайртууд минь, түүхийн туршид Христыг зөвхөн амаараа хүлээн зөвшөөрөгч олон олон хүмүүст өнгөцхөн итгэлээс өөр юу ч байхгүй байсныг бодоод үз дээ Тэд магадгүй багаасаа л цуглаанд явж эхэлсэн. Эсвэл тэд ямар нэг хэмжээгээр өнгөцхөн Христийг хүлээн зөвшөөрсөн ч буцаад л гэмт амьдралаараа амьдарч эхэлдэг. Христчин гэж хэлдэг маш олон хүмүүс үнэндээ жинхэнэ итгэгчид биш байдаг. Энэ бидэнд сануулга болж байна.

Өөр юу гэж байна? Үг хэллэгийн хувьд Христчин үг хэллэгийг хэрэглэсэн байгааг анхаарч хараарай. Энэ бол ёстой чухал юмны нэг Энд хэлэхдээ олон хүмүүс Түүний нэрэнд итгэсэн гэж байна Та нар өмнөх 1-р бүлэгт “ Түүнийг хүлээн авсан болгонд, Түүний нэрэнд итгэсэн болгонд, Бурханы хүүхэд болох эрхийг Тэр өгөв” гэж байдгийг санаж байна уу? Грек хэлээр яг адилхан хэллэг Иохан 1:12 дээр “ Түүнийг хүлээн авсан болгонд, Түүний нэрэнд итгэсэн болгонд” гэж байгаа нь жинхэнэ итгэгчдийг хэлж байна. Тэгтэл энд 2-р бүлэгт “Түүний нэрэнд олон хүмүүс итгэсэн” гэж байна Магадгүй чи “ Өө, тэд жинхэнэ Христэд итгэгчид байна. Христчин хэллэгийг хэрэглэсэн байна” гэж хэлэх байх Гэхдээ библид ихэнхдээ тэдний гаднах байдал, хүлээн зөвшөөрөлийг дүрслэн харуулахдаа Христчин хэллэгийг хэрэглэсэн байдаг ч үнэндээ энэ нь жинхэнэ Христэд итгэгчид гэсэн үг биш. Судраас бид үүнийг харж эхэлмэгц энэ нь үнэхээр бидэнд тусладаг.

Одоо би та нарт энэ Иохан номноос хэдэн хэсгийг харуулмаар байна. Иоханы 8:30 аас эхлэн уншицгаая “Ийн айлдахад нь олон хүн Түүнд итгэх болов.” Магадгүй чи “ Өө, тэд гэмшицгээсэн. Тэд Христэд итгэгчид мөн” гэж хэлвэл үргэлжлүүлэн жаахан уншъя “Есүс Өөрт нь итгэсэн иудейчүүдэд Хэрэв та нар Миний үгэн дотор байвал үнэхээр Миний дагалдагчид байна. Тэгээд та нар үнэнийг ойлгож, үнэн та нарыг чөлөөлнө.” гэсэнд тэд Түүнд: - “Бид Абрахамын үр удам” гэж хариулсан -р ишлэлд “ тэд Түүнд

хариу хэлэв” Та нар дагаж байгаа биз дээ? Энд мэтгэлцээн болж байна. Эдгээр хүмүүс бол Түүний нэрэнд итгэсэн, Түүнд итгэсэн хүмүүс. Тэд нааш цааш хэсэг ярилцсаны эцэст энд 42-р ишлэл дээр “Есүс тэдэнд хэлсэн...” 44-р ишлэлд “ та нар эцэг чинь болох диаволаас гаралтай” гэж хэлсэн. Тэгэхээр энэ хэсэгт Тэрээр Түүнд итгэсэн хүмүүстэй баахан хэлэлцсэний эцэст Тэрээр тэднийг та нарын эцэг бол диавол гэж хэлсэн байна. “итгэх” гэдэг үг үнэндээ жинхэнэ Христэд итгэгчдийг тодорхойлж байгаа юм биш гэдгийг та нар одоо ойлгож байна уу? тэд ямар нэгэн итгэл үнэмшилд хамрагдсан бөгөөд энэ нь өнгөцхөн итгэл байсан байна Тиймээс Тэр эцэст нь “ та нар эцэг чинь болох диаволоос гаралтай” гэж хэлсэн байна.

Бид Матай 13-р бүлэгээс адилхан зүйлийг олж хардаг. Үр суулгахаар гарсан тариачины тухай сургаалт зүйрлэл дээр Есүс хэлэхдээ зарим нь үгийг тэр даруй баяр хөөртэйгээр хүлээн авдаг гэсэн байдагийг санаарай Ийм юм заримдаа болдог. Хүмүүс үгийг тэр даруй баяр хөөртэйгээр хүлээн авдаг. Ер нь Матай 13:20 ыг уншицгаая “Чулуурхаг газар унасан нь үгийг сонсоод тэр даруйдаа баяртайгаар хүлээн авч, харин өөрт нь бат үндэс байхгүй тул түр зуур байдаг аж. Үгнээс болж хавчлага, эсвэл зовлон тохиолдоход тэр дороо л унадаг.” Магадгүй Лук номон дээр “ тэр хэсэг зуур л итгэдэг” гэж хэлсэн байдаг шиг санагдаж байна. Түр зуур итгэх гэсэн ойлголт хаана ч байхгүй Та нар “ тэр баяртайгаар хүлээн авсаныг чи мэдэж байгаа. Тэр аврагдсан гэдгийг би мэдэж байна. Хар л даа ямар их баяр хөөртэй байгааг “ гэхчлэн хүмүүс хэлэхийг сонсдог Үгүй дээ, амьдрал дээр цөхрөлтгүйгээр үр жимс гаргахыг харах хүртэл үнэндээ та нар мэдэхгүй. Энд хэлэхдээ тэд үгийг баяртайгаар хүлээн авдаг ч асуудал тулгарахад дороо л унадаг гэсэн байна. Яагаад ийм юм болов? Та нар ургамлыг гүехэн тарих тусам хурдан соёолдог гэдгийг мэднэ. Өнгөц итгэл үүнтэй л адил Хүмүүс зовж шаналан, тэмцэлдэн байж Христийг хүлээн зөвшөөрөхийг би харах дуртай. Энэ бол чи ганц хоногийн дотор аврагдаж чадахгүй гэсэн үг биш. Гэхдээ энэ нь заримдаа сайны тэмдэг байдаг. Эдгээр хүмүүс бол Христчин болно гэдэг надаас их юм шаардах юм байна гэдгийг ухаарсан хүмүүс юм Харин үгийг тэр даруй хүлээн авагсад тэр дороо л унадаг. Яагаад? Үндэс байхгүй өнгөцхөн учраас тэр За өөр нэг жишээ харцгаая. 2 Петр 2:20 Эндээс эхлэе “Хэрэв тэд ертөнцийн бузар бусармагаас Эзэн ба Аврагч Есүс Христийн мэдлэгээр ангижирсаны дараа” үнэхээр үнэн юм шиг сонсогдож байгаа биз? Эдгээр хүмүүс бол Эзэн Аврагч Есүс Христийн мэдлэгээр ертөнцийн бузар бусармагаас ангижирсан хүмүүс. Үнэмшилтэй сонсогдож байна. “Хэрвээ тэд дахин тэдгээрээр урхидуулан дийлдвэл тэдний хувьд сүүлчийнх нь байдал эхнийхээсээ бүр дор байх болно. Учир нь зөвт байдлын замыг мэдээд, өөрсдөд нь өгөгдсөн ариун тушаалуудаас нүүр бууруулан эргэснээс энэ замыг мэдээгүй байсан нь тэдэнд дээр байхсан.” Хэрвээ та нар “ Хар л даа, тэд Христийн мэдлэгээр ертөнцийн бузар бусармагаас ангижирсан, ариун юмсыг тэд мэддэг боловч тэд эргэсэн байна. Тэд бол авралаа алдсан хүмүүс байна гэж хэлвэл, Петр эдгээр хүмүүсийг хэрхэн дүрсэлсэнийг та нар дараагийн ишлэлээс харж болно. -р ишлэлд тэр хэлэхдээ “ тэдний хувьд “ нохой бөөлжсөө долоодог, хэмээх үнэн сургаалт үгийн дагуу тохиолдсон аж” гэсэн байна. Зүрх сэтгэл нь ерөөсөө өөрчлөгдөөгүй хүмүүс юм. Ойлгож байна уу? Гахайг угаасны дараа шаварт буцаж хөлбөрдөг. Тэдгээр хүмүүсийг жинхэнэ итгэгчид биш гэдгийг Петр мэдэж байсан хэдий ч тэднийг тодорхойлохдоо христчин үг хэллэгийг хэрэглэсэн байна. Юу гэсэн үг вэ гэхлээр, хэрэв чиний мэдэх Христчин ах дүү чинь итгэлээсээ эргэж буцвал чи, “ энэ бол ердөө л нохой бөөлжсөө долоож байна гэж хэлэхгүй биз дээ? Та нар ийм үгийг жинхэнэ итгэгчидэд хэлэхгүй. Тэгэхээр Петр эдгээр хүмүүсийг хэрхэн тодорхойлсоныг та нар ойлгож байна уу? Тэд итгэлээ маш өнгөцхөн хүлээн зөвшөөрсөн. Тэдний гадна

байдлаар нь л тэднийг тодорхойлсон байна.

Тэгэхээр би та нарт дахиад нэг ишлэлийг үзүүлээд энэ тухай ярьцгаая Үйлс 8:13. Энэ хэсэгт илбэчин Симоны тухай гардаг. энд 13-р ишлэл дээр, "Симон хүртэл итгэсэн." гэж байна. " тэр итгэсэн" гэдэг үг энд байж л байна "Баптизм хүртсэний дараа Филиппийг дагах болов." Тэгэхээр тэр итгэсэн, бапизм хүртсэн, үргэлж тэднийг дагадаг байж. "тэрээр гайхамшигууд болон тэмдэгүүд үйлдэгдэхийг харан, үргэлж гайхаж хоцордог байв." Иоханы 2-р бүлэгт гардаг шиг яг адилхан зүйл энд хэлэгдэж байна. Иерусалим дахь элч нар (цаашлаад тэдний залбирал, гар тавилтын талаар хэлж өгч байна) -р ишлэл дээр "Элч нарын гар тавилтаар дамжуулан Ариун Сүнс өгөгдөж буйг ажигласан Симон тэр 2-т мөнгө өгч, - " надад үүнийгээ өгөөч" гэхэд Петр түүнд," Мөнгө чинь чамтай хамт мөхөг." гэж хэлсэн байна Тэр мөхөх болно "Учир нь Бурханы бэлгийг мөнгөөр авч болно гэж чи санажээ. Бурханы өмнө зүрх чинь зөв биш учир энэ үйлсэд чиний хэрэг, чиний оролцоо байхгүй. Энэ хар санаархалдаа гэмшиж Эзэнд залбир. Магадгүй зүрхэн дэхь хар санаа чинь зайлуулагдаж болох юм." гэсэн байна. Энэ бол өнгөц итгэлийн бас нэг жишээ юм. Тэр итгэсэн, тэр баптизм хүртсэн. Яагаад? Тэр зөвхөн хүч, эрх мэдэлтэй болохыг л хүссэн байна. Тиймээс тэр тэдгээр гайхамшиг болон тэмдгүүдийг хараад.... гэх мэт

Тэгэхээр одоо би та нарт үүнийг л хэлье. Хэрвээ та нар итгэгч мэт харагдаж байсан нэгэн итгэлээсээ буцахыг харвал бүү сандарч төөрөлдөөрэй Энэ тухай л бид ярьж байна. Үүнийг мэдэх нь бидэнд их тустай, үр нөлөөтэй байдаг. Паул 2-р Тимот номон дээр Хуменай, Филет нарын талаар юу гэж хэлсэнийг та нар санаж байна уу? Тэд итгэлээсээ төөрөн одож, зарим хүмүүсийн итгэлийг бусниулж байна. Тэд итгэлээсээ төөрөн одсоныг та нар харж байна. Энэ нь та нарыг зовоож байна уу? Миний бодлоор тийм учраас л Есүс дагалдагч нараа эртнээс сэрэмжлүүлсэн байна. "Та нарын нэг чинь надаас урвана" гэж хэлсэн. Иудас эвэртэй сүүлтэй байсан гэж би бодохгүй байна. Есүс " та нарын нэг чинь надаас урвах болно." гэж хэлэхэд тэд юу хэлж байгааг нь мэдээгүй. Тэд бүгдээрээ Иудас рүү эргэж хараагүй нь лавтай. Магадгүй тэр хамгийн сэтгэл булаам аятайхан дагалдагчийн нэг байсан байх. Иудасын итгэлээсээ төөрөн одохыг харах түүнд амаргүй л байсан байх Гэхдээ л Эзэн бүхнийг урьдаас мэддэг гэдгээ тэдэнд харуулахыг хүссэн. Хуменай, Филет нар итгэлээсээ эргэсэн гэж Паул хэлсэн. Паул хэлэхдээ "энэ нь зарим хүмүүсийн итгэлийг бусниулж байна" гээд цааш нь "хэдий тийм боловч Бурханы бат суурь нь хэвээрээ байна. Энэ нь "Эзэн Өөрийн хүмүүсийг таньдаг." "Эзэний нэрийг дуудагч хүн бүр бузар муу явдлаас хол байгтун" гэсэн тамгатай. гэж байна.

За тэгэхээр өнгөцхөн итгэлтэй байх боломжтой. Одоо Еврей 6:4-5 уншицгаая "Учир нь нэгэнтээ гэгээрүүлэгдсэн бөгөөд Бурханы сайн үгийг болон ирэх үеийн хүчүүдийг амссан атлаа..... энэ нь боломжгүй гэсэн байна. Гэхдээ "тэд нар Ариун Сүнсний хуваалцагчид болсон" гэж та нар тайлбарлахыг хичээхгүй биз дээ Зарим хүмүүсийн ойлголтоор тэд ойролцоо очсон гэдэг Гэхдээ асуудлын гол нь Еврей номын эхний хэсэгт "Есүс мах ба цусны тасархай болсон" гэж хэлдэг. Та нар ойлгож байна уу? Хуваалцагч байна гэдэг Тэр үнэхээр хүн байсан гэсэн үг. Та нар цааш нь эдгээр ишлэлийг уншвал христчин үг хэллэгийг л хэрэглэсэн байгаа. Бид үүнтэй сөргөлдөх хэрэггүй. Асуудлын гол библид ихэнхдээ хүмүүсийн аман хүлээн зөвшөөрөл, тэдний гаднах байдлыг дүрслэхдээ Христчин хэллэгийг хэрэглэсэн байдагт байгаа юм. Еврей номон дээр, " Ариун ах дүүс, тэнгэрлэг дуудлагыг хуваалцагчид" гэж хэлсэнийг хүмүүс уншаад, " Нэг л юмыг би мэднэ. Еврей номон дахь хүмүүс бүгдээрээ жинхэнэ итгэгчид" гэж хэлдэг. Үгүй ээ, тийм биш. Хэрвээ

би та нарыг ах дүүс минь гэж хэлсэн ч энэ нь хүн бүр аврагдсан гэдэгт би итгэдэг гэсэн үг биш. Үүнтэй л адил Библийн үг хэллэгийг одоо ойлгож байна уу? “Хэрвээ ах дүүс чинь үхэлд хүргэх нүгэл үйлдэж байхыг чи харвал.....” гэсэн үгэнд бүү бүдрээрэй. Юу гэсэн үг вэ гэхээр энэ нь цуглаанд хамрагддаг нэгнийг л хэлж байна гэсэн үг. Энэ нь тэд үнэхээр Бурхантай хамт алхдаг гэсэн үг биш. Мэдээж та нарт үүнийг мэдэх амаргүй. Нэг талаас харах юм бол, энд байгаа бид бүгдээрээ амаараа л Христийг хүлээн зөвшөөрөгчид байгаа.

“тэгвэл, элч Паулыг авч үзье. Хэрвээ тэр буцаж ирээд өөр сургаал заавал яах вэ?” гэж чи асуул даа Тэр юу гэж хэлсэн бэ? Бид эсвэл тэнгэрээс тэнгэр элч хүртэл өөр сайн мэдээг тунхаглавал тэр хараагдаг гэж хэлсэн. Тэгэхээр Паул хэлэхдээ “тэр ч байтугай Мормон шашинг үндэслэгч Жосиф Смитэд үзэгдсэн тэнгэр элч үзэгдсэн ч түүнийг бүү сонс” гэж хэлж байна Түүгээр ч барахгүй тэрээр хэлэхдээ (энэ үнэхээр гайхалтай биш гэж үү) “хэрвээ би ирэх жил буцаж ирээд өөр юм хэлвэл намайг ч бүү сонс” Бид ч бай, тэнгэр элч ч бай бүү сонс.” гэсэн байна. Та нар үүнийг харж байна уу? Бид хэн нэгэн хүнд итгэл найдвараа тавьж болохгүй. Эцсийн эцэст та нарын итгэл найдвар Бурханд л байх ёстой бөгөөд Тэр Өөрийнхнөө мэддэг, тэднийг харж хамгаалдаг юм. Есүс дагалдагчдынхаа тухай, “Таны Надад өгсөн бүгдээс Би нэгийг ч алдаагүй.” гэж хэлсэн байдаг. Үүний л төлөө Тэр тэнгэрээс бууж ирсэн. Иохан 6-р бүлэг дээр юу гэж хэлдэгийг санаж байна уу? Тэр хэлэхдээ, “Над руу ирэх хүнийг Би огт хөөж гаргахгүй” гэсэн. Юу гэсэн үг гэхээр, хэрвээ та дотор байгаа бол Тэр таныг хөөж гаргахгүй гэсэн үг. Хэрвээ та Түүний хонин сүргийн нэг бол, хэрвээ та жинхэнэ итгэгч бол гэсэн үг. Яагаад Тэр тэднийг хөөж гаргахгүй вэ? Тэрээр хэлэхдээ, “Би Өөрийнхөө хүслийг хийхийн тулд бус, харин Намайг Илгээгчийн хүслийг хийхийн тулд тэнгэрээс бууж ирсэн юм.” гэсэн. Би нэг юмыг гүйцэлдүүлэхийн тулд бууж ирсэн. Тиймээс Би тэднийг хөөж гаргахгүй. “Би Өөрийн хүслийг хийхийн тулд бус харин Намайг Илгээгчийн хүслийг хийхийн тулд Би тэнгэрээс бууж ирсэн.” Эзэн минь, энэ юу гэсэн үг вэ? “Түүний Надад өгсөн бүгдээс нэгийг ч алдахгүй байх нь Намайг Илгээгчийн хүсэл юм. Миний ард түмний авралыг гүйцэлдүүлэхийн тулд Би доош бууж ирсэн юм. Тэдний нэгийг нь ч Би алдахгүй.

Одоо цагт та нар гадна талдаа итгэгч мэт харагддаг маш олон хүмүүс итгэлээ орхихыг харсаар байгаа. Харин тэр хэлэхдээ, “Бурханы бат суурь нь хэвээрээ байна. Бурхан Өөрийн хүмүүсээс нэгийг нь ч алдахгүй гэдгийг та нар мэдээсэй гэж би хүсэж байна” гэсэн байна. Эзэний нэрийг нэрлэгч хүн бүр бузар муу явдлаас хол байгтун. Хэрвээ та Христчин юм бол, христчин хүн шиг л бай. Бузар муу явдлаас хол бай.

За тэгэхээр өнгөцхөн итгэлтэй байх боломжтой. Тэгвэл миний итгэл жинхэнэ үү, биш үү гэдгийг би яаж мэдэх вэ? Би жинхэнэ итгэлтэй юу эсвэл өнгөцхөн итгэлтэй юу гэдгээ яаж мэдэх вэ? Өнгөцхөн итгэлийн шинж тэмдэг юу вэ? 3 зүйлийг би хэлж өгмөөр байна. Нэгдүгээрт, өнгөцхөн итгэл нь эхнээсээ л буруу ойлголтон дээр тулгуурлагддаг. Чухам юу санал болгож байгааг ойлгож ухаараагүй гэсэн үг. Жишээ нь, “Би Есүсийг хүлээж авбал надад ашигтай. Түүнээс би ямар нэгэн юм авна” гэсэн бодол хүмүүст байдаг.

Энд Иоханы 2-р бүлэгт хүмүүс юуг хараад Есүст итгэсэн бэ? Тэд тэмдэг, гайхамшигуудыг хараад ихэд сонирхсон. Талх өгдөг, цирк үзүүлдэг махан биеийн Аврагчийг л санал болгож байна гэж тэд бодсон. Иудей хүмүүсийн бодлогоор тэдний Аврагч ирээд тэднийг Ромын дарлалаас чөлөөлөж, тэгээд Тэр тодорхой намын бодлоготой хаанчлалаа сэргээх ёстой байв. Тэд загалмай дээр тэдний өмнөөс нас барах,

тэднийг гэм нүглээс нь чөлөөлөх Аврагч ирнэ гэж боддоггүй байв. Тэд зөвхөн улс төрийн хувьд, махан биеийн хувьд ерөөх Аврагч ирнэ гэж хүлээж байв Энэ бол өнгөцхөн итгэлийн жишээ. Тэд үнэндээ юу санал болгож байгааг ойлгоогүй.

Иоханы сайн мэдээнээс та нар үүнийг олж харна. Иоханы 4-р бүлэг дээр гардаг худаг дээрх эмэгтэйг аваад үзье л дээ Худаг дээр байсан эмэгтэйд юу тохиолдсон юм бэ? Тэр эмэгтэй, “Эзэн тэр усаа надад өгөөч” гэсэн. Та нар санаж байна уу? Есүс тэр эмэгтэйд амийн усыг санал болгосон. “Эзэн надад тэр усаа өгөөч. Тэгээд би ус авахын тулд дахиж энэ худаг дээр ирэх хэрэггүй болно” гэж эмэгтэй хэлсэн. Тэр эмэгтэй буруу ойлгосон. Мэдээж эмэгтэй аврал гуйсан гэхдээ тэр чухам юу гуйж байгаагаа сайн ойлгоогүй. Есүс түүнд” Хэрвээ чи Бурханы бэлгийг болон чамтай ярьж байгаа хүн хэн болохыг мэдсэнсэн бол чи Түүнээс гуйхад Тэр чамд амийн усыг өгөх байсан” гэж айлдсанд тэр Түүнд,” Эзэн, надад тэр усаа өгөөч.” гэсэн Тэгэхээр энэ эмэгтэй юу асууж байгаагаа ойлгоогүй нь илэрхий байна. Иоханы 6-р бүлэг дээр бас иймэрхүү зүйл гардаг. Иоханы 6-р бүлэгийн эхэнд Есүс 5 талх 2 загасаар 5 мянган хүнийг хооллосон гайхамшигийн тухай гардаг. -р ишлэл дээр, “Хүмүүс Есүсийн үйлдсэн тэмдгийг үзээд, - Ертөнцөд ирэх ёстой өнөөх Эш үзүүлэгч үнэхээр энэ мөн.” гэж ярилцах болжээ. Тэд ирж, Өөрийг нь хүчлэн хаан болгохыг хүсэж байгааг Есүс мэдээд, зайлж ганцаараа дахин уул уруу явлаа. Тэд Түүнийг өөрсдийнхөө хүссэн хаанаа болгоход бэлэн байсан.

Цаашлаад 26-р ишлэл дээр- “Есүс тэдэнд: Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Та нар тэмдгүүдийг үзсэндээ намайг дагаагүй.” гэж хэлж байна Үнэндээ тэд гайхамшиг тэмдгүүдийн утга учирьг ойлгоогүй “харин талх идэж цадсан учраас хайж байна” гэсэн Тэгээд Тэр тэнгэрээс бууж ирэх жинхэнэ талхны тухай хэлсэн. Тэр бол жинхэнэ талх юм. -р ишлэлийг харвал, “Тэгтэл тэд, : Эзэн , энэ талхаа бидэнд үргэлж өгч байгаач гэв.” Бид тэр амийн талхыг хүсэж байна гэж хэлж байна. Худаг дээрх эмэгтэйтэй яг адилхан. Тэр тэдэнд хэрхэн хариулсан бэ? Тэрээр цааш нь тэдэнд хэлэхдээ тэд үнэнээр итгээгүй бас ойлгохгүй байгааг нь хэлсэн. “Эзэн, энэ талхаа бидэнд үргэлж өгч байгаач” -р ишлэл дээр, “ та нар Намайг үзсэн боловч итгэхгүй гэж Би та нарт хэлсэн” Тэгээд Тэр цааш нь жинхэнэ итгэлийн тухай хэлж өгсөн. Тэгсэн ч хүмүүс чухам юу санал болгож байгааг нь буруугаар ойлгож, ямар нэгэн юм авна гэж л бодож байсан. Тэд зөвхөн юм авахын тулд л Есүсийг хүлээн зөвшөөрч байсан. Үйлс номын 8-р бүлэгт гардаг Симон бол бас нэг жишээ юм. Симон итгэсэн, баптизм хүртсэн бөгөөд бас хүч чадалтай болохыг хүссэн. Эдгээр хүмүүс “ бидэнд тэр талхаа өгөөч” гэж хэлж байгаа ч үнэндээ тэд юу гуйж байгаагаа ойлгоогүй байна. Тэр худаг дээрх эмэгтэй ч мөн адил Тэгэхээр энэ л өнгөц итгэлд хүргэдэг байна.

Хайртууд минь, эндээс дүгнэж хэлэхэд, Энэ нь та нар сайн мэдээг хэр зэрэг үнэнээр тунхагласанаас хамаардаггүй Тэр ч байтугай Есүс Эзэн сайн мэдээг бүрэн төгс тунхагласан ч хүмүүс буруу ойлгоод л Түүнд итгэсэн. Өнгөцхөн итгэл Бидний энэ цаг үед сайн мэдээний төлөвлөлт нь өнгөц итгэлд л хүргэж байна. Жишээ нь: Та санхүүгийн талаар чөлөөтэй байхыг хүсэж байна уу? Та амжилтанд хүрэхийг хүсэж байвал Есүс рүү ирээрэй. Та эдгэрэхийг хүсэж байна уу? Хэн эдгэрэхгүй байхыг хүсэх вэ? Зарим нь бүр ч чадварлаг. Та тэр донгоосоо салахыг хүсэхгүй байна уу? гэгцгээдэг. Тийм ээ, та тэр муу зуршил, донтолтоосоо салахыг хүсэж байгаа, гэхдээ энэ чинь Эзэн Есүс Христэд итгэх шалтгаан биш. “Би тийм ч муу биш” гэж өөрийгөө дүгнэдэг Хүн төвтэй сайн мэдээ л тунхагладаж байна. Хэрвээ та Есүсийг хүлээж авбал эдгээр нь байж болно. Манай нутагт нэг хэсэг зарлалын самбар байдаг байсан. Хрисмас баярын

үеэр түүн дээр “ Есүс. Юм юмтай хүн” гэсэн зар тавьсан байсан. Өөрөөр хэлбэл, чи бүхнийг хийсэний дараа зөвхөн энэ интоорыг л орой дээр нь тавиад л чиний хүсэл биелээ гэсэн үг. Та бүх зүйлийг маш сайн хийсэн. Одоо Есүс зөвхөн дуусгах л хэрэгтэй. Үгүй дээ, иймэрхүү замаар биш ээ Бид арчаагүй, нүцгэн, хоосон өрөвдөлтэй. Бид юу ч үгүй Бид арчаагүй цөхөрсөн. Бидний бүхий л талбарт Христ зайлшгүй хэрэгтэй. Хүмүүс: “ Та там руу явмааргүй байгаа биз дээ?” гэж асуудаг. Энэ асуултанд сайн тал байгаа ч хэн там руу явахыг хүсэх вэ дээ? Хэн ч хүсэхгүй. Тэгээд л хүмүүс Есүст махан биеийн дагуу итгэдэг. Тэд там бол гайхамшигт Нэгэнээс бүрмөсөн хагацах хагацал гэдгийг ойлгосондоо бус зүгээр л галаас гарахыг л хүсэж байдаг. Та амар тайван баймаар байна уу? Та аз жаргалтай байхыг хүсэж байна уу? Та төвөгтэй асуудлаасаа салахыг хүсэхгүй байна уу? Тэгье, Тайван бус амьдралаас би бүр залхаж байна. Урагшаа гараад Есүсийг хүлээж авъя. Тэгээд л өөрийнхөөрөө амьдръя Та баяр хөөртэй гэрлэлтийг хүсэж байна уу? Таны гэр бүлд үнэхээр эмх цэгц алга. Хэрвээ та Есүсийг хүлээж авбал баяр хөөртэй гэр бүлтэй болно.

Манай сургууль дээр нэрд гарсан их сургуулийн номлогч ирсэн юм. Магадгүй 20-иод жилийн өмнө юмдаг. Түүний номлол нь “Дээд зэргийн бэлгийн амьдрал” гэсэн сэдэвтэй байсан Коллежийн оюутануудад шүү дээ. Тэгэлгүй яахав маш олон хүмүүс цугларсан. Та хамгийн сайн бэлгийн амьдралтай болмоор байвал Христчин болох хэрэгтэй. Та нар үнэхээр ингэж төсөөлж чадах уу? Энэ бол махан биеийн зүйлээр дамжуулан хүмүүсийг Есүс дээр авчирдаг өнгөцхөн итгэл юм. Тэд одоо аврагдсан гэж боддог ч үнэндээ тэд мэдсээр байж санаатайгаар Бурханыг эсэргүүцэн там руу явдаг. Энэ бол үнэхээр гайхалтай хэрэг. Бүх л юм нь хүн төвтэй. Өнгөцхөн итгэлийг эхлүүлэх хөтлөгч араа бол ямар нэгэн юм Бурханаас авахыг л хүссэн хүсэл байдаг Есүсийг хүлээж авбал хүссэн бүхнээ авч болно Үнэхээр Бурханы хийхийг хүсдэггүй зүйлийн нэг бол тэр. Тэр бол төгсгөл Тэр тэрэгний чинь дугуйн араа шүд байхыг хүсдэггүй Тэр бол Бурхан Тэр : “ Би тэдний Бурхан нь болж тэд Миний хүмүүс болно.” гэж хэлсэн Бурхан таныг авраасай гэж та хүсэж байна уу? Тиймээ, Тэр чиний Бурхан болж чамайг зохистой болгоно “Та намайг авраасай гэж хүсэж байна. Харин Та миний Бурхан байгаасай гэж би хүсэхгүй байна.” Ямар утгагүй сонсогдож байгааг та нар ухаарч байна уу? Энэ бол зүгээр л эхлэл.

Итгэдэггүй хүмүүст гэр бүлийн зөвлөгөө өгөх хамгийн хэцүү байдаг. Тэд ямар нэг юмыг л хүсэж байдаг. Нэг удаа над руу хамт ажилладаг нөхөр маань ирсэн юм. Мотоцикл унасан нэлээн бүдүүн хадуун хүн л дээ. Тэр бүр цухиртлаа уйлаад л “ Би Христчин болмоор байна” гээд л байсан. Тэгээд би түүнтэй хэсэг зуур ярилцсаны эцэст эхнэр нь түүнээс салсаныг олж мэдсэн юм Тэгээд би эцэст нь, “ За тэгэхээр миний бодоход чи үнэндээ Христчин болмооргүй байгаа. Зөвхөн эхнэрээ л буцаж ирүүлэхийг л хүсэж байна. Тийм үү? гэж асуусанд Тэр “ Тиймээ” гэж хэлсэн. Тэгэхээр одоо яахав? Би түүнийг дагуулж залбирч болно л доо Харин эцэст нь юу болох вэ? Бид шинэ дарсыг хуучин тулманд хийхийг хичээвэл юу болох вэ? Есүс хэлэхдээ: Тулам сад тавьж, дарс асгарч тулам хэрэггүй болно гэсэн. Та нар тэр хүн рүү очоод: “ Та аврагдах боломжтой” гэхэд тухайн хүн, “ Би ч хичээсэн л дээ” гэж хэлбэл эндээс бид юуг ойлгох вэ? Тулам задарч, дарс газарт асгарсан байна. Энэ нь юу гэсэн үг вэ? Хүмүүс түүнийг хараад, “ Өө, нөгөө өөрийгөө Христчин гээд байсан хүн чинь гэм нүгэлдээ хутгалдсан хэвээрээ л байна ш тэ “гэцгээдэг. Тэр Христчин байсан гэж хэлдэг. Түүний амьдрал хэрхэн сайн мэдээг гутааж байгааг хар даа?

Тэгэхээр бид хүмүүсийг дагуулж буруу хандлагаар хуурамч залбирал хийлгэхгүй байх нь хамгийн чухал. Миний хэлсэнчлэн хэрэв хэн нэгэн гэрлэлтийн талаар зөвлөгөө авч байхдаа Христчин болохыг

хүсвэл энэ нь үнэндээ их хэцүү байдаг. Тэд үнэхээр Бурханыг хүсэж байна уу эсвэл эхнэрээ л буцааж авчрахыг хүсэж байна уу Охидууд минь, хэрвээ та нар хэн нэгэн залууг өнгөц итгэлтэй эсэхийг батлан хэлж чадахгүй байвал нэлээд цагийг түүнтэй сайханаар өнгөрөөж, сайн мэдээ түүнтэй хуваалцаж, тэгээд дараа нь түүнд “ чи Христчин болохгүй бол би чамтай гэрлэж чадахгүй” гэж хэл. Юу болно гэж бодож байна? Нэг юмуу хоёр долоо хоног эсвэл сар ер нь гэрлэх хүртлээ тэр христчин болдог. Үнэхээр аюултай. Тийм биш гэж үү?

Сохороор юу ч бодолгүйгээр хүлээн зөвшөөрч цуглаанд явж эхэлдэг. Хэн нэгэнд “ Тэд Христчин” гэж хэлэгдэх л чухал байдаг. Тэдний амьдралын хэв маяг өөрчлөгдөж байна уу? тэд сүнсээр өсөж байна уу? гэдэгт анхаарал тавьдаггүй. Энэ тухай л бид энд ярьж байна Өнгөцхөн итгэл бол ямар нэгэн юмыг авахын тулд Есүсийг хүлээн зөвшөөрдөг итгэл юм.

Хоёрдугаарт, энэ нь зөвхөн юу санал болгож байгааг сайн ойлгоогүйгээс болдоггүй, энэ нь харин санал тавьж буй Нэгэнийг буруу төсөөлсөнөөс болдог. Хүмүүс үнэхээр Есүс Эзэн гэдгийг ухаардаггүй. Тэд Түүний тухай маш буруу ойлголттой байдаг. Тэд бодохдоо тэднийг баяр хөөртэй болгодог Санта Клаус шигээр л төсөөлдөг. Тэр тийм биш. Тэр бол Бурхан. Тэр биднийг үнэнч байхыг шаарддаг. Лук номын 14:26 “Хэрэв чи өөрийн эцэг эх хүү эсвэл охиноо Надаас илүү хайрлавал чи Миний дагалдагч байх зохисгүй” гэж хэлдэг. Энэ тухай сайн бод. Харин Хятадын нэрт философч Конфусис бол “ Чи намайг өөрийн эцэг эхээс илүүгээр хайрлах ёстой” гэж хэлэх байсан байх. Харин Тэр тэгэж хэлэхгүй. Үнэхээр Есүс.... бүх юмс Түүгээр болон Түүний төлөө бүтээгдсэн.

Нэг удаа би жаахан охинтой ярилцаж байгаад “Чи Эзэн Есүс Христийг юу гэж боддог вэ?” гэж асуусан юм. Тэр “ би Түүнийг өрөвддөг” гэсэн. “Яагаад?” гэж намайг асуухад Охин хэлэхдээ: “ би Түүнийг өрөвддөг юм. Та тэр зургийг харж байна уу? өрөвдөлтэй Есүс. Тэр гадаа бороонд зогссоор. хаалганд ямар ч бариул алга. Чи Түүнд энэрэнгүй хандаж зүрх сэтгэлдээ оруулахгүй гэж үү? Тэгээд Тэр гадаа бороонд зогсох шаардлаггүй болно тийм үү?” гэсэн юм. Үнэхээр тийм биш. Тэр “ Намайг онгойлгоход хэн ч хааж чадахгүй, Намайг хаахад хэн ч онгойлгож чадахгүй” гэж хэлсэн Та нар Лудиаг санаж байна уу? Үйлс ном 16: 14. Бурхан түүний зүрхийг нээсэнд тэр анхааран сонссон байна. Тэрээр зүрхийг нээх чадалтай. Түүнд бидний энэрэл өршөөл хэрэггүй. Харин Түүний өршөөл энэрэл бидэнд хэрэгтэй. Тэр бол хаан суудалд залрагч Бурхан

Библид хэлэхдээ” Хүмүүс хад чулуунд хандан “ биднийг Хурганы уур хилэнгээс хамгаалаач” гэж хашхирах болно гэсэн. Хурганы уур хилэнгээс далдлаач Биднийг шүүх Нэгэн нүгэлт бидний төлөө нас барсан нь үнэхээр гайхамшигтай юм Үнэхээр гайхалтай биш гэж үү? Хэн ч жинхэнэ Есүст итгэхгүйгээр аврагдаж чадахгүй Та нарт ямар нэг хэмжээгээр сүнслэг ойлголт байх ёстой Эзэн дагалдагч нартайгаа явж байгаад тэднээс: “ Хүмүүс Намайг хэн гэдэг вэ? гэж асуухад тэд: “ зарим нь баптизм хүртээгч Иохан, зарим нь Елиа, зарим нь Таныг эш үзүүлэгчдийн нэг гэдэг” “Харин та нар Намайг хэн гэж хэлэх вэ?” Петр “ Миний бодлоор Та бол Христ гэдэгт би итгэдэг” гэж хэлээгүйг анзаарч харж байна уу? Тэрээр хэлэхдээ: “ Та бол Христ, амьд Бурханы Хүү мөн” гэсэн Есүс юу гэж хэлсэн бэ? “ Бариона Симон оо, чи ерөөлтэй еэ. Учир нь үүнийг чамд мах цус нь биш, харин тэнгэр дэх Миний Эцэг илчилсэн юм” гэсэн Ариун Сүнсээр биш бол хэн ч Есүс бол Эзэн гэж хэлж чадахгүй Хэдийгээр чи эдгээр үгсийг хэлж зүрх сэтгэлээсээ Есүс бол Эзэн гэдэгт итгэсэн ч там руу явах болбол яах вэ? Есүс бол Эзэн гэж хэлсээр байж чадах уу? Хэрвээ

чи хэлж чадаж байвал иймэрхүү мэдлэг зөвхөн Бурханаас л ирдэг. Эцэг Бурхан чамд илчилсэн байна. “Харанхуйгаас гэрэл гэрэлтэг” гэж айлдсан Бурхан бол Христийн нүүрэн дэхь Бурханы алдрын мэдлэгийн гэрлийг өгөхөөр бидний зүрхэнд гэрэлтсэн Нэгэн мөн. Үнэхээр Тэр хэн юм бэ гэдэгийг бага зэрэг ч гэсэн ойлгож байна уу?

Өнгөцхөн итгэлээр үнэхээр Есүс гэж хэн юм бэ гэдгийг мэдэх аргагүй Харин чи бага зэрэг ч болов үнэхээр Тэр хэн юм бэ гэдгийг ухаарвал чи Түүнээс юм авахын тулд мөргөж хүндлэхгүй. Харин Түүнийг хэн болохынх нь хувьд хүндэлж мөргөнө. Яагаад гэвэл Тэр зохистой Хэрвээ чи ингэж чадаж байвал чи өнгөцхөн итгэлтэй биш. Бурхан чамд Есүс бол Эзэн гэдгийг бага ч болов харуулсан байна.

Гуравдугаарт, энэ хамгийн сүүлчийнх Өнгөцхөн итгэл нь Христчин байхын үнэ цэнийг буруугаар ойлгох эсвэл огт ойлгоогүйгээс үүдэлтэй байдаг. Эдгээр хүмүүс Есүсийг хурсан олны адил л дагаж байсан байна. Тэгээд хэсэг хугацааны дараа дагахаа больсон. Эдгээр хүмүүс бол Түүний нэрэнд итгэсэн хүмүүс юм. Тэдний олонх нь хэсэг зуур л Түүнийг дагасан Тэгээд тэд энэ нь нэлээд хол болохыг хараад Түүнийг дагахаа больсон байна. Та нар иохан номыг үргэлжлүүлэн уншвал тэд бүгдээрээ эргэж буцсан байдаг. Есүс дагалдагч нараасаа , “ Та нар бас явмаар байна уу?” гэхэд тэд, “ Эзэн бид хаашаа явах вэ? Мөнх амийн үгс Танд байна” гэж хариулдаг. Хэрвээ ямар нэгэн өөр учир шалтгаан байсан эсвэл тэд үнэхээр Түүний хэн болохыг олж хараагүй бол тэд ч бас зайлан одох байсан биз ээ. Харин тэд үнэхээр Тэр хэн болохыг мэдэж байсан.

Өнгөцхөн итгэл нь Христчин байхын үнэ цэнийг буруугаар ойлгох эсвэл огт ойлгоогүйгээс үүдэлтэй байдаг. Есүс хэлэхдээ, “ Хэрэв хэн нэгэн Намайг дагахыг хүсвэл өөрийгөө үгүйсгэн загалмайгаа үүрэн Намайг дагаг” гэсэн. Амиа аврахыг хүссэн хэн боловч амиа алдана, харин Миний төлөө амиа алдагч хэн боловч түүнийгээ олох болно. Энэ нь чиний аминд ч хүрч болно. Хичнээн чанга зуурсан ч чи амиа алдах л болно. Тэр хэлэхдээ, “ чи амиа алдвал тэгээд түүнийгээ олох болно” гэсэн. Тэрээр бас “чи үүнийгээ мөнх аминд хүртэл хадгалах болно” гэсэн. Амиа аврахыг хүсэгч хэн боловч алдах болно, харин амиа алдагч хэн боловч түүнийгээ мөнх аминд хүртэл хадгалах болно. Лук номын 14-р бүлэгт, “ Хэрэв хэн нэгэн нь Над руу ирж өөрийн эцэг эх, эхнэр хүүхэд, ах эгч дүүсээ төдийгүй өөрийн амийг хүртэл үзэн ядахгүй бол тэр хүн Миний шавь байж чадахгүй.” гэж байна. Тэгэхээр өөрийн гэсэн бүхнээ өргөхгүйгээр хэн ч Миний дагалдагч байж чадахгүй гэсэн үг. Хүмүүс хэлэхдээ “ Өө энэ чинь сүнслэг итгэгчдийг л хэлж байгаа юм” гэдэг. Яагаад Тэр ингэж хэлэв? Учир нь хүн бүх дэлхийг олж авсан ч амиа алдвал ямар ашиг байх билээ? Эсвэл амийнхаа оронд юугаа өгөх билээ? Тэр юуны тухай ярьж байна вэ? Шагналын тухай юу? Жинхэнэ итгэгч байх тухай Тэр ярьж байна.

Хайртууд минь, Тэрээр чиний Бурхан байхаар шийдсэн. Христчин байхын учир утга бол энэ юм. Тэгэхээр Христчин байхын тулд чамаас их золиос шаардана. Тэрээр чиний Бурхан болно. 5 минут завтай байх үедээ тухайн хүний б бодол санаа хаашаа чиглэж байгаагаас хамааран түүний бурхан нь юу болохыг хэлэх боломжтой. Эсвэл юуны тухай ярьж байгаагаас харж болдог. Юу гэсэн үг вэ гэхээр ийм юм. Колледжид цахилгааны инженерийн ангид надад нэг найз байсан юм. Тэр бүх л өдөржингөө цахилгааны инженерийн тухай судалж судалж түүгээр ч барахгүй шөнө нь гэртээ янз бүрийн туршилт хийдэг байсан. Тэр нь түүний амь амьдрал нь байсан. Тэр нь түүний бурхан нь байсан. Тэр цахилгааны тухай л бодож түүний тухай л ярьдаг байсан. Энэ сэдэв л бүх юмны төв нь болж байсан. Энэ нь юу ч байж болно,

төгөлдөр хуурын тухай, эсвэл дасгал гүйлтийн талаар ч байж болно. Унтаж байхдаа ч гүйж байдаг хүмүүс байдаг. Тэр бол тэдний амьдрал. Хэрвээ чи гүйлт болон спортыг шүтэж биширвэл хүмүүс тэгтлээ уурлаж эсэргүүцэхгүй Харин тэд чиний чадвараар л бахархдаг. Тэгсэн мөртлөө хэрвээ чи Бурханд мөргөж эхэлвэл тэд үнэхээр уурладаг. Чиний хийх ёстой зүйл бол Бурханы тухай ярих, библи унших. юу гэсэн үг болохыг ухаарч байна уу? Паул хэлэхдээ “миний хувьд амьдрах нь Христ” гэсэн. Энэ бол зөвхөн супер христэд итгэгчийн тухай биш, жинхэнэ христэд итгэгчийн тухай юм.

Хэрвээ чи үнэхээр Бурханы хүүхэд мөн бол энэ үг үнэн биш гэж үү? Христ байхгүй бол чамд юу ч байхгүй. Чамд амьдрал ямар ч утга учиргүй байх болно. Миний хувьд амьдрах нь Христ юм. Өнгөцхөн итгэлд христчин байхын үнэ цэнийг тооцоолж үздэггүй, үнэнээр гэмшдэггүй, гэм нүгэлдээ харуусдаггүй, ариун байдлыг мөшигдөггүй, Бурханыг мэдэхийн төлөө өлсөж цангадаггүй. Ерөнхийдөө өнгөцхөн итгэлтэй хүмүүсийн хувьд Бурхан бурхан биш байдаг гэж хэлж болно. Тэдний хувьд Бурхан үнэндээ бурхан биш байдаг.

Та нар үнэн авралын баталгаа хуурамч баталгаа хоёрын ялгааг мэднэ. Зүрх сэтгэлийнхээ төлөө санаа зовох үед чинь “ Бурхан намайг аварсан гэдэгт би итгэдэг.” гэсэн авралын баталгаа чамд байдаг. Үнэн болон хуурамч авралын баталгаа нь хоорондоо ялгаатай. Хэрвээ чи хуурамч авралын баталгаатай бол “Бурхан намайг аварсан гэдэгт би итгэдэг. Гэхдээ би Түүнийг дагахгүй, харин өөрийнхөөрөө амьдарна .” гэж хэлдэг. Харин үнэнээр аврагдсан бол, “ Бурхан намайг аварсан гэдэгт би итгэдэг, одоо би бүхий л амьдралынхаа туршид Түүнийг таньж мэдэн, Түүнийг дагана”гэдэг. Энэ бол үнэнээр аврагдсаны шинж тэмдэг.

Сургаал маань бараг дуусах гэж байна. Энэ бүгд бол Есүс хэрхэн зүрх сэтгэлүүдтэй харьцдаг тухай л юм. Тэд Түүний нэрд итгэсэн. Энэ нь үнэнээр биш гэдгийг Тэр мэдэж байсан. Тэр юу хийсэн бэ? Тэр тэдэнд Өөрийгөө даатгаагүй. Одоо цагт юу болдогыг чи мэдэх үү? Хэн нэгэн том цугларалт, семинарын үеэр урагш гарч ирэхэд, пастор номлогчууд түүнийг “Есүсийг хүлээж авлаа” гэж тунхагладаг. Гэтэл Есүс тэдэнд Өөрийгөө даатгаагүй. Тэдгээр ахлагч удирдагчид тэдэнд хэлэхдээ, “ Хэрвээ чи зүрх сэтгэлээ нээвэл, Есүс орж ирнэ” гэсэн. Тэр одоо хаана байна? “Тэр миний зүрх сэтгэлд орж ирсэн юм шиг байна. “ Бурханыг магъя. Одоо чи аврагдсан” Тэд Есүсийг тэдэнд даатгахыг хичээж байна. Харин Есүс Өөрийгөө тэдэнд даатгасангүй.

Есүс зүрх сэтгэлүүдтэй хэрхэн харьцдаг вэ? Тэрээр худаг дээр таарсан эмэгтэйд, “хэрвээ чи чамтай ярьж буй хүн хэн болохыг мэдсэн бол Түүнээс гуйхад Тэр чамд амийн усыг өгөх байсан. “ гэхэд эмэгтэй, “би хүсэж байна. Эзэн, надад тэр усаа өгөөч” гэсэн Харин Есүс тэр эмэгтэй юу хэлж байгаагаа ч ухаарахгүй байгааг олж харсан. Тэр юу хийсэн бэ? Тэрээр “толгойгоо бөхийлгөөд залбирлыг давт” гэж хэлээгүй. Тэрээр, “явж нөхөрөө дуудаад ир” гэж хэлсэн. Анзаарч харж байна уу? энэ бол түүний ярихыг хүсдэггүй нэг зүйл Тэр эмэгтэй олон нөхөртэй байсан. Тэр үед ч нэгэн эртэй хамтран амьдарч байсан байна. Есүс тухайн “асуудалтай эмзэг хэсгийг” хөндөж өнгөцхөн хуурмаг байдлаас жинхэнэ бодит байдал руу шилжилт хийхийг тушаасан. Хүмүүстэй ярилцаж байхад тэд: “Би Христчин болмоор байна” гэцгээдэг боловч үнэндээ тэд юу хэлж байгаагаа ч ойлгоогүй нь илэрхий байдаг. Та нар Бурханаас туслахыг гуй, Ариун Сүнс ирэхийг хүлээ, залбир шаардлагатай бүхнийг хий. Бурхан зүрх сэтгэлийнх нь хамгийн гүн хэсэгт хүрч үнэхээр тэд юу гэж хэлсэнээ ухаарах хүртэл ухаж төнхдөг байна. Тэд чиний юу гэж хэлээд байгааг ойлгож эхэлдэг.

Ойлгож байна уу? Тийм учраас л Эзэн тэр эмэгтэйтэй тэгэж харьцсан байна. Одоо нэгэн баян залуу удирдагчийн тухай авч үзье Надтай ийм байдал хэзээ ч тулгарч байгаагүй. Сам, чамд ийм юм тохиолдож байсан уу? Чамайг гудамжаар явж байтал, нэгэн залуу гүйж ирээд газарт унан, “ Мөнх амиийг авахын тулд би юу хийх ёстой вэ?” гэв Харин чи түүнийг хараад, “ Энэ залуу ч ёстой жүжиглэж байна даа” гэж бодно. Чухамдаа Есүс бас тэгсэн юм. Есүс түүнд, “ Чи тушаалуудыг мэднэ шүү дээ.” гэхэд Залуу “ би бүгдийг сахисан” гэв Энэ залуу сайн гэдэг үгийг маш чөлөөтэй болгоомжгүй хэрэглэж байгааг та нар харж байна уу? Та бол сайн багш. Ямар сайн үйлс би хийх ёстой вэ гэхчлэн Есүс хэлэхдээ: “ Бурханаас өөр хэн ч сайн биш” гэсэн Тэрээр би Бурхан биш гэж хэлээгүй Тэрээр чи сайхан сэтгэл, сайн гэж юу болохыг ойлгодоггүй юм байна гэсэн. Христ “ тушаалуудыг сахь” гэхэд Залуу, “ би тэдгээрийг бага залуугаасаа л сахьсан.” “Надад юу дутагдаж байна?” гэж асуусан. Тэр залуу ямар нэг юмаар дутагдаж байгаагаа мэдэж байсан байна. Есүс, “Чи нэг л зүйлээр дутагдаж байна. Бүх юмаа зараад ядууст өгөөд ирж Намайг дага” гэж хэлсэн. Эд хөрөнгө нь түүний бурхан байсан байна. Тэр л түүний асуудал байв Есүс баян залуу удирдагчид, “Явж эхнэрээ дуудаад ир” гэж хэлээгүй. Тэр түүний асуудал байгаагүй. Түүнтэй адил худаг дээрх эмэгтэйд, “ бүх юмаа зар” гэж хэлээгүй. Есүс шүтээнүүдэд цохилт өгч байгааг харж байна уу? Энэ нь яг Египетэд болсонтой адил. Бурхан ирээд тэдний бурхадыг устгасан. Тэд Нил мөрөнг шүтдэг байсан. Бурхан Нил мөрөнг цус болгон хувиргасан. Та нар мэлхийд дуртай юу? Чи маш их мэлхийтэй болно Харин хүмүүс тэдний бурхад нь устгагдсаныг хараад дургуйцсэн. Фарон: “ Энд үлдээд мөргөлөө үйлдэцгээ” гэж Мосед хэлсэн. Харин Мосе, “ Та үүнд дургүйцэх болно. Яагаад гэвэл Египетчүүдийн жигшдэг юмсаар бид тахил өргөж чадахгүй” гэж хэлсэн Энэ нь Египетчүүдийн жигшдэг юмсаар Израйлчууд тахил өргөх гэсэн утгатай юм байна гэж би боддог байсан. Гэтэл энэ нь тийм утгатай биш байсан. Египчүүдийн шүтдэг юмсыг Израйлчууд тахил өргөвөл энэ нь тэдэнд жигшүүртэй гэсэн үг. Хэрвээ чи хүмүүсийн шүтээнүүдийг устгаж, Бурхандаа өргөл болговол тэд үнэхээр дургүйцнэ. Яг л ийм юм Эзэн Есүс Христийн жинхэнэ чуулганд болдог. Хүмүүсийн шүтээн, бурхадыг алж устган тэднээр тахил өргөхөд хүмүүс дургүйцдэг. Маш ухаантай нэгэн залуу нэрд гарсан технологийн сургуульд явах боломжтой байсан ч, “ Би тэр сургуульд явахаа болилоо. Мишинер авралын зар тараагч болно” гэдэг Боловсрол нь тэдний шүтээн учраас хүмүүс түүний төлөө ухаангүй зүтгэдэг. Хүмүүс янз янзын бурхадтай байдаг. “ Чи чинь яагаад ахих төлөвтэй гайгүй ажлаасаа гараад ийм дэмий юм хүмүүст номлож байхдаа яах вэ дээ” гэгцгээдэг. Одоо та нар ойлгож байна уу? Үнэнээр мөргөгчид дэлхийнхний шүтдэг бурхадыг золиос болгодог. Өөрөөр хэлбэл итгэдэггүй хүмүүст чухалд тооцогддог юм итгэгч хүмүүст тийм ч чухал биш байдаг гэсэн үг. Би түүх хэлэх дуртай. Бүргэд шувуу нуураас загас шүүрч аваад ангаахайнууддаа өгөхийн үүр рүүгээ буцаад нисдэг. Заримдаа тэд хэтэрхий том загас шүүрсэн ч тэр чигээрээ ниссээр ниссээр сүүлдээ бүр ядарч туйлдаад нуурт унадаг. Хүмүүс нуурын эргээс үхсэн загас атгаастай бүргэдийг олдог нь ийм л учиртай аж. Тэр бүргэд загасаа л орхих хэрэгтэй байсан. загасаа тавих л хэрэгтэй Үүнийг л та нар хийх хэрэгтэй. Энэ баян залуу бол яг энэ түүхтэй адил Түүний барьж байгаа загас нь бол түүний эд баялаг нь байгаа биз дээ? Есүс түүнд үүнийгээ орхи, тэгэхгүй бол тэр чинь чамайг доош чангааж сүйрэлд хүргэнэ шүү гэж хэлсэн ч тэр зөвшөөрсөнгүй. Тэгээд уруу царайлан яваад өгсөн байдаг Харин худаг дээрх эмэгтэй түүний хувьд загас болох тэрхүү асуудлаа орхисон болохоор баяр хөөрөөр дүүрч хүмүүст Есүсийн тухай хэлсээр байсан. Есүс тэдэнд Өөрийгөө даатгаагүй. Хамгийн гайхамшигтай хэсгийг чи библиес мэдэх үү? Үнэнээр итгэгчдэд Тэр

Өөрийгөө даатгасан юм. Тэр үнэхээр тэгсэн юм. Тэр Өөрийгөө чамд даатгасан юм. Есүс бол минийх гэж хэлэх нь авралын баталгааны ерөөл юм. Тэр бол минийх Тэр чамд Өөрийгөө даатгасан. Ийм нэгэн түүхээр би сургаалаа дуусгамаар байна. Коллежийн нэг оюутан цуглаанд маань ирдэг байсан юм. Тэр итгэмжтэйгээр үргэлж ирдэг байсан. Оюутны библи судлалд ч тэр. Би түүнийг христчин гэж л боддог байж билээ. Түүнд тиймэрхүү нотолгоо ч байсан. Тэрээр зуны амралтаараа гэр рүүгээ яваад намар нь буцаж ирсэний дараа бид түүнтэй амралтынх нь талаар ярилцсан юм. Тэгээд би энэ охин Эзэний тухай юу ч мэддэггүй болохыг олж мэдсэн юм. Тэр эхлээд “Peace Corps” сайн дурын байгууллагын ажилтан болохыг хүсэж байснаа бид хэсэг ярилцсаны эцэст тэрээр энэ байгууллага христчин байгууллага биш болохыг мэдээд бодлоо өөрчлөн мишиниор болохоор болов. Би түүнтэй энэ талаар удаан ярилцаж Бурхан зочилсон нэг орой түүнд ямар ч авралын баталгаа байхгүй, гэм нүгэлдээ гэмшээгүй нь илэрхий байв. Эхнэр бид 2 түүнтэй ярилцсан юм. Би түүнд, “ Жэни, чи эхлээд Пис Корпсийн ажилтан баймаар байснаа болиод мишинер болохыг хүсэж байна. Жэни, чи буяны байгууллагын ажилтан ивээгч байхыг л хүсэж байгаа юм байна. Дэлхийг тойрч олон газраар яваад л хүмүүст сайн үйлс хүргээд л..... Харин чи Бурханд өөрийнхөө амьдралыг даатгаад Түүний хүслээр байвал ямар вэ? гэж асуулаа. Тэр тэнд хэсэг зуур сууж энэ тухай бодлоо. Тэгээд толгойгоо сэгсрэв. Тэр христчин байхаас илүүтэйгээр сайн мэдээ тараагч номлогч байхыг хүсэж байв. Би иймэрхүү байдалтай өмнө нь хэзээ ч тулгарч байгаагүй юм даг. Тэгээд би түүнд том загасны тухай түүхийг хэлж өгөөд, “чи энэ шүтээнээ орхих хэрэгтэй дээ” л гэж хэлсэн юм. Хэдэн долоо хоногийн дараа тэр буцаж ирлээ. Авралын баталгаагүй хэвээрээ л байгаагаа тэр бидэнд хэлэхэд нь би түүнд “Чи тэр загасаа л хаях хэрэгтэй. Тэгэхгүй бол Бурхан чамайг хэзээ ч сонсохгүй шүү” гэж хэлсэн юм. Тэр, “за би хаянаа” гэсэн. Би түүний залбиралд дагуулж ч юмуу өөр ямар нэгэн юм юу ч хийгээгүй. Зөвхөн “ Чи Бурханы өргөөний үүдэнд очоод өршөөл энэрэлийг гуй. Хэрвээ Тэр чамайг энэрч өршөөхгүй бол энэ нь Түүний өргөөний босгонд унагсадыг авраагүй хүмүүсийн эхнийх нь чи байх болно л гэж хэлсэн юм. Маргааш өглөө нь хаалга цохих чимээнээр Мона тайлж өгсөн юм даг. Нөгөө охин гараа алдлаад зогсож байв. Тэр, “ Би аврагдсан, би аврагдсан” гэж хэлсээр байсан. Чухам юу болчихов? Тэр загасаа хаясан болохоор Есүс Өөрийгөө түүнд даатгасан байна. Энэ л нөгөө өнгөцхөн байдал, жинхэнэ бодит байдал 2-ын ялгаа юм даа. Үүнийг л бид өөрсдөдөө ч бус бидний эргэн тойронд байгаа итгэлээ зөвхөн амаараа хүлээн зөвшөөрөгч хүмүүст зөвлөж байхдаа хийхийг Бурхан биднээс хүсдэг. Бид маш болгоомжтой байх хэрэгтэй. Хамтдаа залбирах цаг гэж бий. заавар залбиралыг давтаж залбирах цаг ч гэж бий. Бид хүмүүсийн хэлэх үгийг заах ёстой гэж би бодохгүй байна. Гэхдээ тийм цаг байж болно. Хамгийн гол нь бид тэдний амьдралд Бурхан юу хийж байгаад л мэдрэмтгий байх хэрэгтэй юм. Бас өөр нэг коллежийн охин зөвлөгөө авахаар ирсэн юм. Бид маш олон зүйлийн талаар ярилцсан юм. Бурхан тэнд байж түүнд бодол ухаарал өгч байгаа нь илэрхий байсан. Би түүнд, “ Эзэн Есүс минь Таны нигүүлсэлээр би Таныг миний Аврагч гэдэгт би итгэж байна” гэж чин сэтгэлээсээ хэлж чадах уу? гэхэд Тэр, “ Би чаднаа” гэсэн. Би түүнд “чи нэг иймэрхүү залбираарай” гэсэн. Эзэн Есүс минь Таны нигүүлсэлээр би Та бол миний аврагч гэдэгт би итгэхийг хүсэж байна бас итгэж байна. Үүнийг Та өөрийнхөө цагт Өөрийнхөө замаар надад үнэн, бодит болгож өгөөч гэж би гуйж байна. Тэр иймэрхүү маягаар залбирсан. Дараа нь би залбирсан. Залбирсаны дараа бид нүдээ нээгээд хартал тэр туяаран, мишээж байлаа. Тэр үнэхээр бодит болгосон гэж хэлж байв. Есүс Өөрийгөө түүнд даатгасан байлаа. Ямар урамтай хэрэг вэ. Эдгээр охидууд одоо ч Бурхантай хамт явсаар байгаа. Тэд одоо

хижээл насны эмэгтэйчүүд бас гэрлэцгээсэн. Тэд тийм ч хижээл насны эмэгтэйчүүд биш харин тэд гэрлэцгээсэн. Үргэлжлүүлэн итгэсэн хэвээр Эзэнийг дагасан хэвээр байгаа. Ийм л байх ёстой юм даа. Есүс хэлэхдээ Түүнд зүрх сэтгэлээ бүрэн зориулагсдыг хамгаалах болно гэсэн юм.